

Бөөгийн оргой малгайд урласан хүний хөрөг дүрийн зохиомжийн онцлог

Дашзэвэгийн Амараа 

Соёл урлагийн их сургуулийн Дүрслэх урлагийн академи,
Улаанбаатар, Монгол Улс
✉ khurugart@gmail.com

Хураангуй: Бөө мөргөлтэй ард түмний дунд түгэн дэлгэрсэн тусгай зан үйлд зориулсан өвөрмөц хувцас, эд хэрэглэл урлах соёл уламжлалын нэршил, утга тайлал нь тухайн овог угсаатны шүтлэг, амьдралын хэв маяг зэрэг олон хүчин зүйлээс хамаарч харилцан адилгүй өөр өөр онцлогтой байдаг. Бөөгийн хувцасны соёлын салшгүй хэсэг бол малгай өмсгөл бөгөөд задгай оройтой оргой хэмээх малгайн их бие дээр утга бэлгэдэл агуулсан зураг дүрсүүдийг урлахуйн уламжлалт арга, зохиомжийн дэг зурлагыг баримтлан өвөрмөц өнгө төрхтэй урлаж иржээ.

Уг судалгаанд оргой малгайн нэршил болоод хэв загвар, урлах арга барил, хүний хөрөг дүрийн онцлог, уламжлалыг тодруулах, зохиомж, өнгө, дүрсийн зохист харьцааны талаар өгүүлэхийг зорилоо.

Түлхүүр үгс: *онгод, язгуур дүрс, тэгш хэм, самалга, орон зай*

The characteristics of the design of human portraits embroidered on a shamanic Orgoi headwear

Amaraa Dashzeveg 

Academy of Fine Arts, Mongolian National University of Arts and Culture,
Ulaanbaatar, Mongolia
✉ khurugart@gmail.com

Abstract: The terminology and interpretation of the unique clothing and artifacts created for specific rituals among shamanistic communities significantly due to various factors, including the spiritual beliefs and lifestyle of the ethnic groups. An essential part of this shamanistic clothing culture is the headwear, particularly the “Orgoi” hat, which features an open crown. The body of this hat is traditionally adorned with symbolic imagery crafted using conventional methods and design principles, resulting in a distinct aesthetic appearance. Aims of this study elucidate the terminology, design patterns, crafting techniques, and distinctive features of human imagery in shamanic headgear, as well as the associated traditions, composition, color, and appropriate relationships between forms and symbols.

Keywords: *spirit, ancestral motifs, samalga, symmetry*



Оршил

Бөөгийн хувцас хэрэглэл болон түүнтэй холбоотой эд өлгийн зүйлсийг урлаж бүтээсэн арга технологи, дэг уламжлал нь дүрслэх урлагийн томоохон судлагдахуун болдог. Үүнд уран дархан, арьсан урлал, хувцас загвар, нэхмэл хатгамал, сийлбэр, чимэглэх урлаг зэрэг олон төрлийг нэгтгэсэн онцлогт урлахуйн соёл уламжлал нь олон зууныг дамжин өвөрмөц хэв маяг дүр төрхөө хадгалан өнөөг хүрч иржээ. Энэхүү бөөгийн хувцасны соёлын нэг хэсэг оргой малгайн талаар онцлон өгүүлж, бусад дурсгалуудтай харьцуулах, дүр дүрслэлийг ангилах, урлах арга барил, утга бэлгэдлийг судлан тодруулахыг хичээв. Уг судалгаанд дотоод гадаадын судлаачдын судалгааны бүтээлд хэвлэгдсэн 8, Монголын үндэсний музейн сан хөмрөгт буй биет үзмэр 4, Хөвсгөл аймгийн музейд буй биет үзмэр 1, нийт 13 ширхэг оргой малгайг хамруулсан бөгөөд №1-13 хүртэл дугаарлаж хэрэглэсэн болно (*Зураг 1*). Эдгээр оргой малгайнууд нь бүгд их бие дээрээ хүний хөрөг дүртэй бөгөөд 10 оргой нь 1960 оны үед дархад бөө нарын хэрэглэж байсан эдлэл юм. 1959-1962 оны хооронд угсаатны зүйч С.Бадамхатан Хөвсгөл аймгийн дархад угсаатны дунд хээрийн судалгаа хийх үедээ № 3, 4, 7, 9 зэрэг оргой малгайнуудыг авч музейд шилжүүлсэн бөгөөд одоо Монголын үндэсний музейн сан хөмрөгт байна. Мөн судалгаанд орсон № 6, 7, 8, 11 дугаартай оргой малгайн гэрэл зургуудыг Унгарын угсаатны зүйч Диосеги Вилмош (1923-1972) авсан юм. Тэрээр 1960 онд Монголд 3 сар хээрийн судалгаа хийж, бөөгийн 100 гаруй эд өлгийн зүйл, 800 гаруй гэрэл зураг авчээ (Чулуун 2023, 4). Оргой малгайд хүний хөрөг дүртэй хамт дүрсэлсэн саглагар мод, нар, сар, шулуун дүрсүүд, эвэр зүүлт, хонхинуур зэрэг бусад эд зүйлийн талаар нарийвчлан судлах шаардлагатай учир хожмын судалгаандаа дэлгэрүүлж өгүүлэх болно.

Хүн (удган, зайран)-онгод гэсэн биет, биет бус хоёр дүрийн хоорондын харилцаа хамаарал, нэг цул биет болж нэгдэх, хувирах үзэгдлийн гол илэрхийлэх зүйл бол бөөгийн хувцас бөгөөд бодитоос бодит бус тодорхой заагтай орших орон зайд шилжихэд чухал үүрэгтэй. Энэхүү хувцасны үүрэг, зориулалт нь тухайн хүнийг (бөөг) муу нөлөөнөөс хамгаалах, ... өмсгөл нь бөөгийн өмсгөл биш онгон сахиусны өмсгөл (Бадамхатан 1965, 233) гэж үздэг байна. Бөөгийн хувцсанд малгай бол чухал үүрэгтэй бөгөөд битүү оройтой (даавуу, амьтны арьс, өд сөд, эвэр, төмөр тоног), оройгүй (даавуу, шувууны өд сөд, гөрөөсний арьс, малын ноос, үс, явуу, төмөр тоног) гэсэн хоёр үндсэн хэлбэр зонхилдог. Малгайн нэршлийн тухай түүхч Ч.Далай бугын эврийн дүрсийг цутган отго болгон суулгасан төмөр буюу оргой гэдэг малгай өмсөнө (Далай 1959, 32), мөн Я.Цэвэлийн толь бичигт оргой [oryui] бөө нарын онгодоо тайж урихдаа өмсөх малгай (Цэвэл 2013, 584) гэсэн тайлбар зүүлт хийжээ. Бөө судлаачид Даяндээрхийн халх бөө нар товорцог, ... буриад, барга, хорчин зэрэг Зүүн монголын бөө нар товорцог, буриадаар майхавч (Пүрэв 2006, 190), Баруун монголын бөө удган нар ихэнх нь намхан оройтой малгай өмсөж, зарим нь алчуураар толгойгоо боодог (Далай 1959, 32) тухай бүтээлдээ дурдсан байна. Угсаатны зүйч, эрдэмтэн С.Бадамхатан Цаатан бөө нар бөртө (Бадамхатан 1965, 39), урлаг судлаач Л.Батчулуун дөрвөд, баядын нутагт намхан оройтой товь малгай өмсдөг (Батчулуун 2021, 9-17) хэмээн онцлон өгүүлжээ. Буриад бөөгийн

даавуун малгайг гавал, төмрөөр хийсэн эвэр зүүлт бүхий тоног өмсгөлийг бөөгийн дуулга (Баре 2023, 224) гэж тэмдэглэсэн байна. Дээрх судлаачдын судалгаанаас үзэхэд, бөөгийн малгайн нэрийг тухайн газар орон, овог угсаатны онцлог шинж хэв маягаас үүдэн зарим нутагт оргой, алчуур, товарцог, майхавч, товь, бөртө, гавал, дуулга хэмээн дуудаж заншжээ. Бид энэхүү судалгаандаа түүхч Ч.Далай, судлаач С.Бадамхатан, О.Пүрэв болон Л.Батчулуун нарын бүтээлд дурдагдсан бөөгийн малгайн нийтлэг нэршил болох оргой нэрийг хэрэглэв.

Хүний хөрөг дүртэй бөөгийн “Оргой” малгай (Монгол улс)

 №1. Дархад бөөгийн малгай. Хөвсгөл аймгийн музей.	 №6. Бөөгийн эд хэрэглэл. Угсаатны зүйн музей. Диосеги Вилмош (Будапешт), (Бирталан Агнөш, 2020, 93)
 №2. Бөөгийн хувцас хэрэглэл. Монголын үндэсний музей (National Museum of Mongolia 2009, 106)	 №7. Дархад бөөгийн малгай. Монголын үндэсний музейн сан хөмрөг.
 №3. Дархад бөөгийн малгай. Монголын үндэсний музейн сан хөмрөг.	 №8. Бөөгийн малгай. Монгол улс, Улаанбаатар хот. Улсын төв музей. (Чулуун, 2023, 83)
 №4. Дархад бөөгийн малгай. Монголын үндэсний музейн сан хөмрөг.	 №9. Дархад бөөгийн малгай. Монголын үндэсний музейн сан хөмрөг.
 №5. Цагаан соёот бөөгийн малгай. Хөвсгөл аймгийн музей. (Чулуун, 2023, 83)	 №10. Дархад бөөгийн малгай (Бадамхатан, 1965, 243)
Тува бөөгийн Оргой малгай (ОХУ)	
 №11. Бөөгийн малгай. (Дзевлет, 1980, 248)	 №12. Бөөгийн малгай (Вайнштейн, 2016, 318)
 №13. Бөөгийн малгай. (Вайнштейн, 2016,)	

Зураг 1. Монгол Улс, Тува (ОХУ) бөөгийн оргой малгайн дүрслэлийг судлаачдын авсан гэрэл зураг, гар зураг, биет үзмэрээс сэргээн зурав. Зургийг Д.Амараа.

Судалгааны арга зүй

Бөө судлалын талаар томоохон судалгаа хийсэн түүхч Ч.Далай, судлаач С.Бадамхатан, О.Пүрэв, С.Дулам нарын хээрийн судалгааны тайлан, бүтээлд нийтлэгдсэн аман сурвалж, музейн эрдэм шинжилгээний ажилтны тайлбар болон эх хэрэглэгдэхүүнийг судлан, гэрэл зураг, гар зургаар баримтжуулалт хийж дүр дүрслэлийн утга бэлгэдэл зүйг харьцуулан дүгнэх, загварчлах, тоон утгаар харьцааг илэрхийлэх зэрэг судалгааны аргыг ашигласан.

Судалгааны үр дүн


Бөөгийн хувцас урлах үйл явц нь онгодын хүсэлт хэрэгцээ, болзолт шалгуурт нийцэх тогтсон дэг жаягтай агаад урлах бүтээх санаа сэдэл, дүр дүрслэлийг урлаач өөрийн хүслээр үйлдэх бус онгодын чиглүүлэг заавар, уламжлалын дагуу урладаг. Бөө судлаач О.Пүрэв малгайн задгай оройны талаар, онгодтойгоо толгойн оройгоор шууд харьцаж бөөлдөг учраас бөө малгай оройгүй болсон (Пүрэв 2006, 196) хэмээн дурджээ. Энэхүү малгайг урлах арга барил, ашигласан материал зэргээс харахад, тухайн угсаатан ард түмний сэтгэлгээ, шүтлэг бишрэл, амьдралын хэв маяг, газар нутгийн онцлог шинжийг өөртөө агуулсан байдаг. Оргойг урлахдаа нүүдэлчид ахуйдаа эртнээс түгээмэл хэрэглэж ирсэн дүрслэх урлагийн нэгэн төрөл зээгт наамал, хатгамлын аргыг хослуулан биет хэлбэр үүсгэх, эрчилсэн утас, даавуу, цаа буга болон амьтны үс, сур, явуу, өд зэрэг материал ашиглах бөгөөд холбоо, хөвөрдөх, шидэх, хавах үйл урлал, арга ажиллагаа шаарддаг. Явуу чимэглэл нь утга бэлгэдэл агуулахаас гадна хөдөлгөөн, дуу авиа, биет хэлбэр, орон зай үүсгэх, бараан дэвсгэр дээр цагаан өнгө ялгарч дүрсээ улам тодруулах үүрэгтэй ажээ (Зураг 2).



Зураг 2. Оргой малгай дахь хүний хөрөг дүр урлах арга ажиллагаа, материалын онцлог шинж (оргой № 4, 7, 9, 5)

Оргой малгайн оройгүй загвар нь дээд хэсэг, их бие, доод хэсэг гэсэн гурван хэсгээс бүрдэнэ. Бөө мөргөлд тоон утга илэрхийлэл, үзэл ойлголтууд түгээмэл агаад түүхч Ч.Далай бүтээлдээ гурван ертөнцийн тухай ойлголт ертөнцийг үзэх үзлийн гол хэсэг нь болдог (Далай 1959, 42) гэсэн бол, судлаач С.Дулам гурвалжин дүрсийн бэлгэдэл утга нь хүмүүн, тэнгэр, газар гурвын хэлхээ, орчлон ертөнцийн бичил загвар бэлгэдэл (Дулам 2018, 61) хэмээн үзжээ. Оргой малгайд энэхүү бичил ертөнцийн загвар буй бөгөөд дээд хэсэгт жигүүртний өд өөдөө тэмүүлэх босоо чигтэй гурвалжин тэнгэр, их бие дээрх хүний дүрс бол тэнгэр газрын холбоос, дамжуулагч үүрэгтэй хүмүүн, доод талын олон өнгийн цацаг байдлаар сул унжуулах нүүр царайг (бөө) хаах хамгаалах зориулалт бүхий самалга (Пүрэв 2006,

196) нь доош чигтэй гурвалжин газар хэмээх ойлголтыг бэлгэдэж байна. Мөн гурван ертөнц (дээд, дунд, доод тив), орон зай (ирээдүй, одоо, өнгөрсөн) цаг хугацааны илэрхийлэл юм. Их биеийн зохиомжид буй хүний хөрөг дүр төвтэй бусад дүрсийн харьцаа хамаарал нь хүмүүн - тэнгэр (нар, сар), хүмүүн - газар (саглагар мод), хүмүүн - орон зай (дүрс) хэмээн илэрхийлэгдэх ба хоёрдогч дүрсүүд (саглагар мод, нар сар, орон зай)-ийг хүний хөрөг дүрийн хоёр талд үргэлж хосоор нь тэгш хэмтэй урладаг онцлогтой.



*Зураг 3. Оргой малгайн үндсэн бүтэц
(дээд хэсэг, их бие, доод хэсэг)*


*Хэвтээ (оргой)-босоо (сүүл нуруу) дээрх
дүрсийн байрлал. а) Оргой малгай дүрсүүд
(Вайнштейн 2016, 318). б) Хорол удганы
өмсгөлийн дүрсүүд (Пүрэв 2006, 237)*

Тэнгэр (босоо цагаан гурвалжин), газар (хөмөргөн хар гурвалжин) (Дулам 2018, 61) хоёр дүрсийн давхцал давхар чойнжин буюу зургаан өнцөгт гурвалжинд багтсан дүрсүүдийг амьдчилан үзэх, тэдгээрийг үл үзэгдэх өөр өөрийн эзэдтэй (Батчулуун 2021, 118) хэмээх тайлал, мөн уг дүрсүүд салангид бус нэгдмэл, цул бүхэл хэмээх утга илтгэнэ. Бидний судалж буй оргойд хэвтээ хэмжээс дээр дүрсийг шугаман аргаар төв голчтой байдлаар өрдөг бол бөөгийн оройтой малгайн ар хэсэг, өмсгөлөөс зүүдэг “сүүл нуруу” (Пүрэв 2006, 237) хэмээх нарийн урт босоо хэмжээст дээр мөн адил загвараар дүрсээ байрлуулдаг. Энэхүү хэвтээ-босоо хэмжээсийн дүрсийн тэгш хэмт зохиомжийн харьцаа, дараалал нь үндсэндээ адил бөгөөд нүдэнд харагдаж байгаа бус, утга санаагаа байх ёстой тодорхой тэмдэгт дүрээр харьцуулан илэрхийлэх (Батчулуун 2021, 119) үндсэн зарчмыг баримтлах бөгөөд ертөнцийг дүрст хураангуйлж шингээсэн хэлбэр юм (Зураг 3). Оргой малгай дүрсийг утга бэлгэдэл, хэлбэр агуулгаар нь:

- а) Үндсэн дүрс (хүмүүн)
- б) Язгуур дүрс (мод, нар, сар)
- в) Үүсмэл дүрс (тэмдэгт) хэмээн ангилж үзлээ.

Дээрх а), б), в) дүрсүүдийн байрлал, эрэмбэ дараалал нь зохиомжийн зохист харьцаагаар илэрхийлэгдэх бөгөөд а) Үндсэн дүрсийг 50%-аас багагүй хэмжээтэй

дүрсэлдэг. Жишээлбэл, оргой №1-д а) 50%, б), в) дүрс нийлээд 50% гэсэн хувь хэмжээс нь оргойн тогтсон дараалал, тэг зурлага гэж үзэж болно (Зураг 4).



Зураг 4. Оргой малгайн үндсэн, язгуур, үүсмэл дүрсийн зохиомжийн харьцаа

Бөө мөргөлд өнгө хэмээх ойлголт нь бодит ба бодит бус бэлгэдлийн шинжтэй бөгөөд орон зай (зүг чиг), шим ертөнц (газар орон, лус, харын, шарын, цагааны тэнгэрүүд) тоо хэмжээс (55, 44), эзэн дүр (онгод савдаг, хүн, амьтан)-ийг илэрхийлдэг. Судлаач О.Пүрэв бүтээлдээ (2006) бөөгийн шашинд хорвоогийн өнгө, хүний сэтгэл санааны өнгө, яс овгийн өнгө гэж гурав хувааж үздэг хэмээсэн нь бөө мөргөлд өнгөний талаарх үзэл баримтлал сэтгэлгээний маш дээд түвшинд хүрснийг илтгэнэ. Оргойн үндсэн өнгөнд хар, улаан өнгө зонхилох бөгөөд хүний сэтгэл санаанд хүчтэй нөлөөлдөг өнгөнүүд юм. Самалганд дан хар өнгөнөөс гадна олон өнгийг (дулаан хүйтэн) дагнаас байдлаар хоршуулсан нь бэлгэдлийн утгатай. Өнгөний ерөнхий харьцааг харахад, дээрээс хар бараан цул өнгө, доош зөөлөрч самалганд олон өнгө хуваагдан өнгөний шилжилт харагддаг. Энэ нь бөө бөөлөх үед олон өнгө хөдөлгөөнд орж хувьсан өөрчлөгдөж байдаг (Хавсралт I).

Хүний хөрөг дүрийн утга бэлгэдэл: Бөө мөргөлд онго, онгод буюу бодит ба бодит бус хүн төвтэй сэтгэлгээний ойлголт нь оргой малгайн дээр хүний хөргийг томоор дүрсэлж, дүрийг чухалчлан үзэж буйгаас харагдана. Хүн дүрслэл нь бөөгийн онго, хувцас, хэнгэрэг болон бусад эд зүйлд нэгэн адил дүрслэгдэх бөгөөд цөм нэгдэж утга бэлгэдэл бүхий цогц урлаг болж илэрхийлэгддэг. Бөө мөргөлд оргой малгайн талаар ихэвчлэн аман яруу найрагт домог зүйн хэлбэрээр үлдсэн ба Цаатан Тож бөө нарын тамлагад:

Долоон өдтэй малгай минь
Лагшин тунгалаг уу?


Хамт нисье. Хамт нисье гэсэн тамлага бий. Оргойд урласан хүний хөрөг дүр нь онгон, сахиусыг дүрсэлж бүргэд болон хувирч нисэхийг уриалсан утга бүхий (Бадамхатан 1965, 234) хэмээжээ. Дархадын Жамбын Дамдин зайрангийн өгүүлсэн Гунан Улаан баатрын домгийг¹ угсаатны зүйч С.Бадамхатан тэмдэглэж авсан

¹ "...Малгай дээрх хүний дүрс нь Чингисийн үед бурхны шашинтай тэмцэлдэж байсан хойд зүгийн баатар бөгөөд эвэртэй лустай тэмцэлдэж дийлсний нь бэлэг дурсгал болгож малгайн өдний хажуу талд эвэр хадах болсон гэнэ. Малгайн өд буруу харуулж хадсан учир нь тэр Гунан улаан баатар лустай тэмцэхдээ өөрийгөө танигдуулахгүйн тул малгайгаа буруу харуулдаг болсон гэнэ..."

бөгөөд Халхын Гунан Улаан баатар домогтой төстэй учир хожим үүссэн домог гэж үзсэн байна. Бөө судлаач О.Пүрэв уг саналыг дэмжиж бурхны шашны дэлгэрэлттэй холбоотой болох талаар бүтээлдээ бичжээ. Оргойн их биеийн үндсэн улаан өнгийг хөрөг дүртэй холбон хар дархад, маанжраг ясны зайран бөө нар малгай дээрх хүний хөрөг дүрийг орон дэлхийн тийрэн, савдагтай нөхцсөн бөө хүний толгой бөгөөд улаан хүрэн, ногоон өнгө нь тэрхүү тийрэн савдгийн царай юм (Пүрэв 2006, 194) гэсэн сонирхолтой тайлбар хийжээ. Урлаг судлаач Л.Батчулууны бөө удган нар шүтдэг онгоныхоо нүүр, толгойг дүрсэлсэн (Батчулуун 2021, 16) гэж үзсэн таамаг илүү бодитой байж магад. Энэхүү хөрөг дүртэй холбоотой дээрх тайлбаруудаас үзэхэд, Гунан Улаан баатар, тийрэнтэй нөхцсөн савдаг зэрэг хувь бодгаль шинжтэй дүрүүд байгаа бол оргой №4-д гурван хөрөг дүр урласан нь олон онгод даадаг, зэрэг буудаг үйл явцыг буюу тэдгээр онгодын дүрийг зэрэгцүүлэн урласан байж болох юм. Бөө бөөлөх үед удмын онгодоос гадна ойр тойрны онгодууд орж ирдэг (Чулуунбаатар 2006, 146) талаар судалгааны баримт²-д дурдсан байна. Шарнууд овгийн Гүнгийн Галын дархад удганы хамгаалагч онгодын дээд хэсэгт буй гурван төмөр хүний дүрсийн тухайд зүүн талын дүрс нь түүнд туслагч алдартай онгод болох Агарын хайрхан удган, голд буй нь онгодын хүү, баруун талынх нь түүний охин хэмээн тайлбарлажээ (Бирталан Агнеш 2020, 82-87). Онгодын дүрслэлийг ийнхүү хамгаалагч онгодын хөрөг, Байгаль аав хэмээн нэрлэсэн нь оргой дээрх хөрөг дүрийн нэршил, утга илэрхийлэлтэй холбоотой байж болох юм.

Урлахуйн онцлог: Оргой малгайд дүрслэгдсэн хүний хөрөг дүрийг урласан арга барил нь:

- а) Хүний нүүр хүрээтэй (№ 3, 4, 5, 6, 13)
- б) Хүний нүүр хүрээгүй (№ 1, 2, 7, 8, 9, 10, 11, 12)
- в) Хүний нүүр чимэглэх (явуу) (№ 6, 7, 8, 9) хэмээн харьцуулалт хийв (Зураг 5).




Зураг 5. Хөрөг дүрийг урлах арга барил

Эдгээр оргой малгайн зохиомж, үндсэн хэв загвар адил бөгөөд дүрсийн хувьд хязгаарлагдмал цөөн өгөгдөлтэй боловч урлах арга барил, материал, өгүүлэмж нь давтагддаггүй учир өөр өөрийн хэв маяг онцлог шинжийг агуулдаг. Жишээлбэл, оргой №2, 9, 11-д дүр, дүрслэлийг ерөнхий байдлаар харуулсан бол оргой №1, 13-

² "...2005 оны зун Хөвсгөл аймгийн Улаан-Уул сумын Соёо багийн бөө Доржийг бөөлөх үед 7 онгод орж ирлээ хэмээн хэлсэн байсан. 2004 оны зун Хөвсгөл нуурын хөвөөнд бөөлсөн 70 гаруй настай Долгор удган 11 онгод орж ирлээ хэмээж байсан..."

ийн урласан арга барил нь тэгш хэмт үндсэн зохиомжийг баримталсан хэдий ч их биеийн өнгө, шулуун зураас, дүрсийн хөдөлгөөн, орон зайн тоглолт нь бусад оргойн дүрслэлээс эрс ялгарна. Дүр дүрслэлийн хэмжээ харьцаа, байрлалын тухайд гадна ерөнхий хэлбэрт (өд, их бие, самалга) шугаман хуваалт хийж үзэхэд, хөрөг дүр зохиомжийн төв цэгт таарч байгаа нь зохист харьцаа буюу хөрөг дүр чухал байр суурь эзэлж буйг илтгэнэ. Доорх зурагт оргойн их биеийн голлох босоо төв шугам тэгш өнцөгтийн захаас холбоход гурвалжин өнцөгт дүрс үүсгэх ба зохиомжийн голлох үндсэн, язгуур зурлагууд огтлолцож байна. Оргойн урлалын үндсэн зохиомж бол хүний хөрөг дүрийг ямагт голлох төвд байрлуулах бөгөөд хүрээлсэн дүрсүүд нь хэлбэр дүрс, зурлага нь өөрчлөгдөн хувьсдаг бол зарим оргойд язгуур, үүсмэл дүрсүүдийг огт дүрслээгүй зөвхөн хүний хөрөг дүрийг дангаар нь урласан сонирхолтой юм (Зураг 6).



Зураг 6. Бөөгийн оргой малгайн дүрслэл дэх зохиомжийн харьцаа


Оргой малгайн их бие дээр хүний хөрөг бүтээхдээ нүүрний хэлбэр болон нүд, хөмсөг, хамар, ам, хацар, чих зэрэг долоон сүвийг (Пүрэв 2006, 193) дүрслэх, арга барил, хэллэгийн хувьд бага зэрэг ялгаатай хэдий ч тогтсон уламжлалыг ямагт баримталдаг. Зарим хөрөгт хүний зан авирын онцлог шинжүүдийг тод томруун харуулахыг эрмэлзсэн байдаг (Зураг 7). Хүний хөрөг дүрийн зарим дүрслэл болох ам №12, чихийг №9, 11 оргойд урлаагүй байгаа нь сонирхолтой бөгөөд XIII-XIV зуунд хамаарах зарим зөвхөн хөрөг дүртэй хүн чулуунд (Зүүн нүхт, Сүхбаатар) мөн адил хөргийн чих, ам зэргийг дүрслээгүй нь зан үйлийн болон бэлгэдлийн хувьд төстэй байж болох юм. Хадны сийлмэл зурагт (Хахуулын гол, Өмнөговь) бөөгийн малгайн оройд байдаг салаа эвэр, өд?, мөн хоёр хацрыг дүрсэлсэн “уул усны эзэн савдаг” (Эрдэнэбат 2008, 36-56) дүртэй болно. Оргой №1, 2-т хөргийн хацрыг хоёр дугуй дүрсээр улаан, цагаан өнгөтэй урласан бөгөөд хацрыг улаан өнгөөр дүрсэлсэн нь амин сүнс гэж үздэгтэй холбоотой хэмээн О.Пүрэв (2006) бичжээ. Зарим бөөгийн малгай урд хэсэгтээ хүний хөрөг дүрийг биет хэлбэр баг (маск) байдлаар мод, металаар урлаж, нүүрийг халхлан зүүх бөгөөд дүрслэлийн хувьд эртний чулуун соёлд дүрслэгдсэн онго шүтлэгтэй (тотем) адил хэв маягтай (Зураг 8). Эдгээр баг (маск) нь оргойн хөрөг дүр, доод хэсэг самалгатай нэгэн адил тэрхүү бөө, удганы нүүрийг халхалж танигдуулахгүй болгож байгаа зүйл (Бадамхатан 1965, 209) бөгөөд хамгаалалтын үүрэгтэй ажээ.

	Зураг. №1	Зураг. №2	Зураг. №5	Зураг. №6	Зураг. №9	Зураг. №10	Зураг. №11	Зураг. №13
НГД ХӨМӨСӨГНИЙ ХЭЛБЭР								
ХАМАРЫН ХЭЛБЭР								
АМНЫ ХЭЛБЭР								
ЧӨГНИЙ ХЭЛБЭР								

Зураг 7. Оргойд урласан хүний хөрөг дүрслэлийн харьцуулалт


Хэлэлцүүлэг

Дээрх бүх оргойд дүрслэгдсэн хөрөг дүрийн нийтлэг шинж нь эгц өмнө талаас харсан дэлгэмэл байдлаар урлах арга нь хадны зураг, хүн чулуунд дүрслэгдсэн хөрөг дүрийн зохиомж дүрслэлээс уламжлалтайг илтгэнэ. Шүтлэгтэй холбоотой цалиг дүр, сүлд дүр, онгодын дүр (Дулам 2018, 157-166) дүрслэлийн уг сурвалж, урлахуйн эх үндэс язгуур сурвалжийг тодруулахад эртний урлагт буй хөрөг дүрслэлтэй харьцуулж үзэх нь чухал юм (Зураг 9). Хадны зураг дахь хүний нүүр дүрслэлийг судлаачид хүний нүүрийн баг (Батболд 2021, 123), хүний нүүрний дүрст хадны зураг (Ван Сиаокун 2021, 16) гэж нэршиж хэрэглэж, шүтлэг бишрэл, зан үйлтэй холбон тайлбарлажээ. Бөөгийн хувцас хэрэглэл, овог, ясны сүлд онгод, язгуур шүтлэгийн хэлбэр агуулгатай дүр дүрслэл нь тэр чигтээ залгамж байдлаар өвлөгдөн удам дамжин уламжлагдах үйл явц бөгөөд байгаль дээр юу ч шинээр үүсдэггүй юмс үзэгдэл зөвхөн тойргоор л эргэлдэж байдаг (Овсянников 1987, 157) хэмээх Гегелийн үзэл санаатай нийцнэ. Оргой малгайн урлалаас бөөгийн бусад хувцас, эд өлгийн зүйлс дээрх бэлгэдэлт дүрсийг харж болохоос гадна заавал дүрслэгдэх кодлогдсон дүрсүүд байх ба тэдгээрийн утга агуулга нь шүтлэг, зан үйлийн (хориг, цээр) шинж давамгайлдаг. Бөөгийн оргойд урласан хүний хөрөг дүр болон бусад дүрслэлээс зураас зурлага, донж хэтрүүлэг, урлахуйн сэтгэмжээр илэрхийлэгдэх хүн-байгаль, газар-тэнгэр, бодит-хийсвэр, бэлгэдэл-зан үйл, уламжлал-сэтгэлгээ, биет-биет бус, арга-билэг, тэгш хэм-тиг зохирол, хэмнэл-хөдөлгөөн, цаг хугацаа-орон зай, алслал-зүг чиг, энерги-тэнцвэр, хатуу-зөөлөн, гэрэл-сүүдэр гэсэн агуулга шинж чанаруудыг хураангуй хэлбэрээр илэрхийлэх дүрслэх чадвар нь урлаачийн уран сэтгэлгээний илрэл юм.



Зураг 8. Шүтлэгийн зан үйлтэй холбоотой хүний хөрөг дүр дүрслэлийн харьцуулалт.

1. Хүний дүр бүхий чулуун онго зүүлт. Дорнод аймаг. Монголын үндэсний музей. 2. Жаргалантын адгийн ширээгийн хадны сийлмэл зураг. Сүхбаатар аймаг. (гар зураг Д.Амараа). 3. Ягшийн хөдөөгийн хүн чулуу. Ховд аймаг. Хүрлийн эхэн үе. Монголын үндэсний музей. 4. Хүний дүр бүхий хүрэл цутгуур. ОХУ, Алтай. 5. Шавар вааран дээрх хүний хөрөг дүр. Хүннүгийн үе. Салхит, Дархан хот. 6. Хүний дүрслэл бүхий бөөгийн оргой малгай. Монгол. Диосэги Вилмошийн гэрэл зураг



Зураг 9. Хадны зураг болон хүн чулуун дахь хүний хөрөг дүрслэл.

Хадны зураг (Монгол): 1-2 Сүхбаатар, Жаргалантын адгийн ширээ, (гар зураг Д.Амараа). 3-5 Өмнөговь, Хахуулын гол (Хаданд сийлсэн эртний урлаг. 2022, 29). 6. Өмнөговь, Цагаан бухтын гол. (Т.Санжмятав гар зураг. 1988). 7. Өмнөговь, Цагаан дэрсний Бичигтийн ам (Хаданд сийлсэн эртний урлаг. 2022, 28). **Хадны зураг (ОХУ):** 1-7 .Мугур-Сарголын хадны зураг. (М.А.Дэвлет 1980, 49-143). **Хадны зураг (БНХАУ):** 1-2 Авга хошуу, Байшин худаг, (Авга музей), 3-6 ӨМӨЗО-ны Улаанхад хотын хадны зураг. (Ван Сиаокун 2021, 47, 52). **Хүн чулуу (Монгол):** 1-5 Сүхбаатар, Зүүн нүхтийн хүн чулуу (Д.Амараа 2021, 90)

Дүгнэлт

Манай улсад 1960 он хүртэл бөөгийн хувцас хэрэглэл нь уламжлалт байдлаа хадгалан хэрэглэгдэж ирснийг С.Бадамхатан, О.Пүрэв, Диосэги Вилмош зэрэг судлаачдын судалгаа, олж цуглуулсан бөөгийн холбогдолтой эд өлгийн зүйлсээс тодорхой харж болно. Эдгээр оргой малгайн хувилбаруудаас үзэхэд, урлах хэв загвар, арга технологи нь цаг хугацааны явцад хувцасны соёлын хэлбэр болж бүрэлдэхэд овог удам дамжих (тотем, онго шүтлэг) эртний уламжлалаа дагаж мөрдөх, чанад баримталдаг зарчим нөлөөлсөн. Бөөгийн хувцас эд өлгийн соёл нь нийтэд түгсэн соёл бус цөөнхийн тусгай хэрэглээ, хэрэгцээ бөгөөд нууцлаг шинж агуулдаг, шүтлэг зан үйлтэй холбоотой хэмээн үздэг учир тун бага судлагдаж иржээ.

1. Бөөгийн оргой малгай нь хэв маяг, ур хийц, утга бэлгэдлийн хувьд бие даасан шинж агуулах ба хүний хөрөг дүрийг урлах олон янз арга барил, хэлбэр харагддаг. Бодит дүр дүрслэлээс татгалзаж, зөн бэлгэдэл, шүтлэг (хориг, цээр) давамгайлсан хийсвэр дүрслэлээр илэрхийлэхдээ тогтсон урлахуйн арга ажиллагааг баримталдаг. Үүнд:
 - а) Хөрөг дүрийг эгц өмнө талаас харсан тэгш хэмт дэлгэмэл арга
 - б) Зохиомжийн үндсэн шийдэл, дүрсийг байрлуулах эрэмбэ дараалал
 - в) Хураангуй ерөнхий дүрслэл, шулуун зураас, геометрийн дүрс
 - г) Загварчилсан хөрөг дүр дүрслэл нь багны (маск) хэлбэр агуулах

Хүн чулуу бол бодит эзэнтэй, тахилга тайлгын зан үйлийн зориулалт бүхий дурсгал гэж үздэг бол оргойн хөрөг дүр, онгод мөн адил ад зэтгэр, тийрэнг дарах, зайлуулах, төөрүүлэх, эзнээ (бөө) муу зүйлээс хамгаалах үүрэгтэй дүр гэж үздэг. Оргойн хөрөг дүрийг тойрсон биет зүйлс, хос дүрс, зурлага, зураас, цэг болгон харилцан хамаарал, холбоос үүрэгтэй бөгөөд бүгд утга бэлгэдэл агуулдаг.

2. Хадны зураг, хүн чулуу, эртний онго зэрэг шүтлэг, зан үйлийн дурсгалуудад урласан хүний хийсвэр дүрслэлийг ерөнхийлөн харьцуулах аргаар үзэхэд, зохиомжийн арга барил нөлөө тусгал харагдах бөгөөд хүний хөрөг дүрслэлийн эртний язгуур хэв шинж зурлага нь оргой малгайн хөрөгт илүү хадгалагдаж үлдсэн байна.
3. Бөөгийн хувцасны үндсэн агуулга хүн-байгалийн харилцаа, оршихуйн үндэс шим ертөнц хийгээд “Тэнгэр, газар, хүмүүн” гурвалсан холбоосын үр дүнд бий болсон бодит ба бодит бус сэтгэлгээний илрэл оргой малгайны загварт тусгалаа олжээ. Бүс нутаг, газар зүйн байрлалаас шалтгаалан хадны зураг, хүн чулууны хөрөг дүрслэл нь онцлог ялгаатай байдаг бол уг судалгаанд хамрагдсан дархад (Монгол), Тува (ОХУ) бөөгийн оргой малгайн ур хийц, хэв маягт томоохон өөрчлөлт ялгаа үгүй бөгөөд учир нь дархад, Тува угсаатнууд бол нэг бүс нутагт амьдардаг, амьдралын хэв маяг, соёл ахуй, зан заншил адил төстэй юм. Цаашид халх, буриад, бусад угсаатнууд болон эртний бөө мөргөлтэй бусад улс орнуудын ижил төстэй малгай өмсгөл, эд өлгийг харьцуулан өргөн хүрээнд судлах шаардлагатай байна.

4.

Талархал: Монголын үндэсний музейн сан хөмрөгт буй бөөгийн оргой малгай судалгаа хийх нөхцөл бололцоогоор хангасан Монголын үндэсний музейн захирал Г.Энхбат (Ph.D) болон тус музейн хамт олонд талархал илэрхийлж цаашдын ажилд нь өндөр амжилт хүсье.

Ашигласан материалын жагсаалт

- Амараа, Д. 2021. “Сүхбаатар аймгийн Эрдэнэцагаан сумын “Зүүн нүхт”-ээс шинээр илрүүлсэн хүн чулууд.” *Монголын археологи-2021. Эрдэм шинжилгээний хурлын эмхэтгэл*. Эрх. Амартүвшин, Ч. Улаанбаатар.
- Бадамхатан, С. 1962. *Хөвсгөлийн цаатан ардын аж байдлын тойм*. Улаанбаатар: Шинжлэх Ухааны Академийн хэвлэл.
- Бадамхатан, С. 1965. *Хөвсгөлийн дархад ястан*. Улаанбаатар: Шинжлэх Ухааны Академийн хэвлэл.
- Батболд, Н. 2014. “Хадны зураг дахь эртний нүүдэлчдийн шүтлэг бишрэл оршуулгын зан үйлтэй холбогдох нь.” *Археологи судлал. Томус XXXIV*. Улаанбаатар.
- Батчулуун, Л. 2012. “Бөөгийн хувцас, тоногийн учир холбогдол.” *Mongolica VoL* (45). Улаанбаатар.
- Батчулуун, С. 2020. “Нүүдэлчдийн уран сайхны сэтгэлгээний онцлог.” *Монголын дүрслэх урлаг, дизайны хөгжил*. Улаанбаатар.
- Бирталан Агнеш. 2020. *Унгар дахь монголын өв соёлын дурсгалууд*. Улаанбаатар: Адмон
- Болдбаатар, Ч. 2000. “Монголын хадны зургийн уран сэтгэмж дүрслэлийн сакраль шинж.” Ph.D дисс., Монгол Улсын Соёл урлагийн их сургууль.
- Бум-Очир, Д. 2017. *Монгол бөөгийн зан үйл: Аман яруу найргийн төрөл зүйлс*. Улаанбаатар: МУИС Пресс хэвлэлийн газар.
- Вайнштейн С.И. 1975. *История народного искусства Тувы*. Москва.
- Ван Сиаокун, Жан Вэнжин. 2021. *Хадны зураг дахь шүтлэг*. Улаанбаатар.
- Далай, Ч. 1959. *Монголын бөөгийн мөргөлийн товч түүх*. Улаанбаатар: Шинжлэх ухаан, дээд боловсролын хүрээлэнгийн эрдэм шинжилгээний хэвлэлийн газар.
- Дулам, С. 2018. *Домог зүй, бөө мөргөлийн судалгаа: Эрдэм шинжилгээний өгүүллийн чуулган*. Улаанбаатар: МУИС Монгол судлалын хүрээлэн.
- Кристал Брае. 2023. *Дани дахь монголын өв соёлын дурсгалууд*. Улаанбаатар.
- Luvsanjav, Chuluunbaatar. 2006. “Монгол бөөгийн онгодын хүч”
- Овсянников М. Ф. 1987. *Гегель*. Улаанбаатар: Улсын хэвлэлийн газар.

Пүрэв, О. 2006. *Монгол бөөгийн шашин*. Улаанбаатар.

Rolf Gilberg. 2024. *Mongolian and Siberian Shamans*. Yale University press, Aarhus University press. The national Muzeum Of Denmark.

Цэвэл, Я. 2013. *Монгол хэлний их тайлбар толь*. Улаанбаатар.

Чингис хаан үндэсний музей. 2023. *Диосэги Вилмошийн Монголын тухай гэрэл зургууд (1960)*. Ред. Чулуун, С., Батболд, Н., Силалы Жолт. Улаанбаатар.

Эрдэнэбат, У. 2008. “Хахуулын голын хадны зураг.” *Археологи судлал. Том (VI) XXVI*.

Хавсралт 1.

Оргой малгайн хэлбэр, өнгө, дүрсийн харьцаа

№	Зураг. №3	Зураг. №4	Зураг. №9																																								
Үндсэн ОРГОЙ																																											
Өнгөний харьцаа	<table><tr><th>Хар өнгө(өд)</th><td>42.8%</td></tr><tr><th>Улаан хүрэн өнгө(их бие)</th><td>19.3%</td></tr><tr><th>Ногоон өнгө(самалга)</th><td>12.2%</td></tr><tr><th>Цэнхэр өнгө(самалга)</th><td>8.5 %</td></tr><tr><th>Цагаан өнгө(самалга)</th><td>17.2%</td></tr></table>	Хар өнгө(өд)	42.8%	Улаан хүрэн өнгө(их бие)	19.3%	Ногоон өнгө(самалга)	12.2%	Цэнхэр өнгө(самалга)	8.5 %	Цагаан өнгө(самалга)	17.2%	<table><tr><th>Цайвар бор өнгө(их бие)</th><td>27.0%</td></tr><tr><th>Бор хүрэн өнгө (өд)</th><td>23.7%</td></tr><tr><th>Улаан өнгө (самалга)</th><td>10.8%</td></tr><tr><th>Цагаан өнгө(самалга)</th><td>10%</td></tr><tr><th>Хар өнгө(самалга)</th><td>3.65%</td></tr><tr><th>Цайвар цэнхэр(самалга)</th><td>3.65%</td></tr><tr><th>Ногоон өнгө(самалга)</th><td>7.3%</td></tr><tr><th>Баруан цэнхэр өнгө (самалга)</th><td>7.3%</td></tr><tr><th>Улбар шаргал өнгө (самалга)</th><td>7.3%</td></tr></table>	Цайвар бор өнгө(их бие)	27.0%	Бор хүрэн өнгө (өд)	23.7%	Улаан өнгө (самалга)	10.8%	Цагаан өнгө(самалга)	10%	Хар өнгө(самалга)	3.65%	Цайвар цэнхэр(самалга)	3.65%	Ногоон өнгө(самалга)	7.3%	Баруан цэнхэр өнгө (самалга)	7.3%	Улбар шаргал өнгө (самалга)	7.3%	<table><tr><th>Улаан өнгө(их бие)</th><td>26.1%</td></tr><tr><th>Бор хүрэн өнгө (өд)</th><td>20.1%</td></tr><tr><th>Ногоон цэнхэр өнгө (самалга)</th><td>14.0%</td></tr><tr><th>Цайвар ногоон өнгө(самалга)</th><td>14.0%</td></tr><tr><th>Бор шаргал өнгө(самалга)</th><td>10%</td></tr><tr><th>Цагаан өнгө (самалга)</th><td>15%</td></tr></table>	Улаан өнгө(их бие)	26.1%	Бор хүрэн өнгө (өд)	20.1%	Ногоон цэнхэр өнгө (самалга)	14.0%	Цайвар ногоон өнгө(самалга)	14.0%	Бор шаргал өнгө(самалга)	10%	Цагаан өнгө (самалга)	15%
Хар өнгө(өд)	42.8%																																										
Улаан хүрэн өнгө(их бие)	19.3%																																										
Ногоон өнгө(самалга)	12.2%																																										
Цэнхэр өнгө(самалга)	8.5 %																																										
Цагаан өнгө(самалга)	17.2%																																										
Цайвар бор өнгө(их бие)	27.0%																																										
Бор хүрэн өнгө (өд)	23.7%																																										
Улаан өнгө (самалга)	10.8%																																										
Цагаан өнгө(самалга)	10%																																										
Хар өнгө(самалга)	3.65%																																										
Цайвар цэнхэр(самалга)	3.65%																																										
Ногоон өнгө(самалга)	7.3%																																										
Баруан цэнхэр өнгө (самалга)	7.3%																																										
Улбар шаргал өнгө (самалга)	7.3%																																										
Улаан өнгө(их бие)	26.1%																																										
Бор хүрэн өнгө (өд)	20.1%																																										
Ногоон цэнхэр өнгө (самалга)	14.0%																																										
Цайвар ногоон өнгө(самалга)	14.0%																																										
Бор шаргал өнгө(самалга)	10%																																										
Цагаан өнгө (самалга)	15%																																										
Ерөнхий хэлбэр (гадна өнгөний харьцаа (хүнд хөнгөн))																																											
Самалгааны үзүүрийн хэлбэр																																											